

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Олон талт хамтын ажиллагааны бодлого хариуцсан мэргэжилтэн (Азийн хөгжлийн банк), Тамир Зэндмэнэ

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавина.							
1	Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтран ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авна.	Хэрэгжилтийн явц, хувиар	Хоёр талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх 5 санамж бичиг, 2 протокол байгуулсан Нийт 22 хэлэлцээрийн төсөл, 26 ярианы сэдэвт санал боловсруулж, холбогдох чиг үүргийн яамдад хүргүүлсэн	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	Хөрш орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, нэгдсэн зохицуулалтаар хангах хүрээнд “Торгоны зам” олон улсын ралли уралдааныг ОХУ-тай хамтран зохион байгуулах асуудлаар нэгдсэн зохицуулалтаар хангаж ажилласан. Түүнчлэн ДЦС-3 өргөтгөл, шинэчлэлийг ОХУ-тай хамтран хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн. Хоёр талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлогыг төлөвлөхөд дэмжлэг үзүүлж ажилласан. Тухайлбал Худалдаа, техникийн эдийн засаг, шинжлэх ухаан, хамтын ажиллагааны Монгол, Узбекистаны, Монгол, Киргизий Засгийн газар хоорондын комиссын хуралдааны монголын талын баримтлах удирдамж, яриа хэлэлцээний сэдэв, хамтран хэрэгжүүлэх боломжит төсөл арга хэмжээ, хоёр улсын бизнес эрхлэгчдийн харилцаа холбоог сайжруулах, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал боловсруулж хүргүүлсэн. Мөн Казахстан Улстай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2025-2027 онд эрчимжүүлэх замын зураглалыг судалж, санал боловсруулсан. Хоёр талт болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг нэгдсэн төлөвлөлтөөр хангах, зохицуулах хүрээнд	
--	--	--	--	--	--	--

					өндөр, дээд айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний уялдаа, холбоог хангаж ажилласан. Хоёр талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Бүгд Найрамдах Узбекистан, Бүгд Найрамдах Словак, Бүгд Найрамдах Туркменистан, Япон улсуудтай худалдаа, байгаль орчин, зам тээврийн чиглэлээр байгуулах Засгийн газар хоорондын нийт 12 хэлэлцээрийн төсөлд тухай бүр санал бэлдэж, байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан: Олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд ОХУ, БНХАУ, Солонгос Улстай хамтран хэрэгжүүлдэг Их түмэн санаачилга хөтөлбөрийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж ажилласан. Энэ хүрээнд тус 3 улстай зам тээвэр, эрчим хүч, худалдаа, хөрөнгө оруулалт, зэрэг салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, 4 жилийн хамтын ажиллагааны үйл		
--	--	--	--	--	---	--	--

					ажиллагааны стратеги хөтөлбөрийг байгуулахаар ажиллаж байна.		
2	Худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч салбар хоорондын уялдааг хангана.	Хэрэгжилтийн явц, хувиар	Өндөр, дээд түвшний 45 уулзалт, удирдлагын түвшинд 59 уулзалт зохион байгуулсан. Түнш улс орон, олон улсын байгууллагатай хөгжүүлсэн харилцаа, хамтын ажиллагааны мэдээллийн сан, бүрдүүлэн тухай бүр шинэчилж ашигласан.	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	АХБ-ны хэрэгжүүлж буй урт хугацааны стратеги (Стратеги-2030), баримталж буй зээл, тусламжийн бодлого, бусад улс орнуудад хэрэгжүүлж буй үйл ажиллагааг судлан цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх саналыг боловсруулж Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн АХБ- ны Ерөнхийлөгч Масацүгү Асакаватай хийх уулзалтын ярианы сэдэвт санал бэлтгэж хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газар, АХБ 4 жилийн хугацаанд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа, чиглэлийг тодорхойлсон үндсэн баримт бичиг болох Түншлэлийн стратегийг шинэчлэн тохиролцох хүрээнд тус банкнаас баримталж буй бодлого, өмнөх түншлэлийн стратегийг, түүний үндсэн чиглэл болон үр дүнг судалсан ба шинээр байгуулах 2025-2028 оны	1-р сар, 2- р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Түншлэлийн стратегийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, тохиролцоход дэмжлэг үзүүлж ажиллаж байна. АХБ-аас Монгол Улсад хуваарилагдах зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тохирох хүрээнд Монгол Улс, АХБ-тай 2024-2027 онд хамтран ажиллах салбар, баримтлах чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тохиролцож Харилцан ойлголцлын санамж бичгийн төслөөр баталгаажуулахад бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Монгол Улсын Засгийн газар АХБ-тай хамтран хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тодорхойлдог “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр 2025”-ыг байгуулах, хамтран хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эцэслэн тохиролцох ажлыг эхлүүлсэн. АХБ-тай 2024-2027 онд хамтран хэрэгжүүлэх боломжит нийт 31 төсөл, арга хэмжээг судалж, Монгол Улсын богино, дунд, урт		
--	--	--	--	--	--	--	--

					хугацааны хөгжлийн бодлоготой нийцэж буй эсэхийг нягталж, тухай бүр удирдлагад танилцуулж, холбогдох саналыг боловсруулж, салбар яамд болон АХБ-тай хэлэлцсэн. 2024 онд нийт 7 төсөл, хөтөлбөрийн Зээлийн хэлэлцээрийг байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд нийт 31 уулзалт зохион байгуулж, тухай бүр бэлтгэл ажлыг хангаж ажилласан: Сайдын түвшинд – 9 Төрийн нарийн бичгийн даргын түвшинд – 10 Газрын даргын түвшинд - 12		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь

	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрийн хариуцсан ажлын хүрээнд мэдлэг, мэргэшлээ дээшлүүлсэн байх.	Сургалтад хамрагдсан байх.	Сургалтад хамрагдсан байна. /100%/	Сургалтад хамрагдсан байна. /100%/	Өөрийн хариуцсан ажлын хүрээнд мэдлэг, мэргэшлээ дээшлүүлсэн зорилгоор нийт 6 сургалтад хамрагдсан: АХБ-ны Гүйцэтгэх захирлын зөвлөх Д.Эрдэнэтуяагийн АХБ-ны дотоод үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй арга хэмжээ болон түншлэлийн стратеги байгуулахад анхаарах асуудлын талаар сургалтад хамрагдаж мэдлэг, мэргэшлээ дээшлүүлсэн. АХБ, Сангийн яам хамтран зохион байгуулсан Гадаадын зээл, тусламжийн удирдлага, зохицуулалтын сургалтад хамрагдсан. 2024.05.09-ны өдөр АХБ, Сангийн яам хамтран зохион байгуулсан Гадаадын зээл, тусламжийн төслийн хэрэгжилтийг үнэлэх, хянах, сайжруулах сургалтад хамрагдсан. Англи хэлний мэдлэг дээшлүүлэх сургалтад 2 сарын хугацаанд хамрагдсан. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ханжоу хотод зохион байгуулагдсан "Цахим эдийн засаг" сургалтад хамрагдаж, нийт 84 цагийн хичээл буюу 4 цагийн нээлтийн хичээл, 56 цагийн танхимын хичээл, 24 цагийн танхимын бус хичээлд суралцаж мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. Олон улсын валютын сангаас зохион байгуулсан "Өөрийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					удирдлага, өрийн тайлан, хөрөнгө оруулагчдын харилцаа" сэдвийн сургалтад хамрагдсан. АНУ-ын Дьюкийн их сургуулиаас зохион байгуулсан "Ногоон эрчим хүч" сэдэвтэй сургалтад хамрагдсан.		
2	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна /100%/	Байгууллагаас зохион байгуулсан мэдээллийн цагт тухай бүр хамрагдсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Олон талт хамтын ажиллагааны бодлого хариуцсан мэргэжилтэн (Азийн хөгжлийн банк), Тамир Зэндмэнэ

/.....Т.Зэндмэнэ...../

Огноо: 2024.12.18